



ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Дугаар № 06/2022

2022 оны 01-р сарын 19 өдөр

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Амгалан дулааны станц ТӨХК –ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх/цаашид захиалагч гэх/нөгөө талаас Инженер геофизи ХХК-ийн захирал Ц.Билэг /цаашид гүйцэтгэгч гэх/хамтад нь/ цаашид талууд гэх / нар нь Монгол улсын иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний зорилго

1.1. Гэрээний зорилго нь Амгалан дулааны станц ТӨХК-д Инженер геологийн судалгааны ажил гүйцэтгэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

Хоёр. Гэрээний нөхцөл, хугацаа, ерөнхий зүйл

- 2.1. Амгалан дулааны станц ТӨХК-д Инженер геологийн судалгааны ажлыг 2022 оны 01-р сарын 19-ний өдрөөс 2022 оны 02-р сарын 01-ний дотор хийж дуусгана.
- 2.2. Гүйцэтгэгч нь Инженер геологийн судалгааны ажлыг Монгол Улсын БНБД болон холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, Захиалагч нь гэрээгээр тохиролцсон ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлөх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.
- 2.3. Талууд энэхүү гэрээний дагуу ажиллахдаа Монгол Улсын Барилгын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, барилгын норм дүрэм болон гэрээний заалт бүрийг дагаж мөрдөнө.
- 2.4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахаар бол талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ. Нэмэлт өөрчлөлт хавсралт нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд түүний нэгэн адил хүчинтэй байна.
- 2.5. Талуудын аль нэг нь нөгөө талын зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
- 2.6. Гүйцэтгэгчийн хийх судалгааны ажилд инженер-геологийн судалгааны ажил багтана.
- 2.7. Гүйцэтгэгч нь ажлыг стандартын шаардлагад нийцүүлэн чанарын өндөр түвшинд гүйцэтгэнэ.
- 2.8. Гэрээний дагуу гүйцэтгэх ажлын төсөв нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 2.9. Гэрээт ажлыг хээрийн ажил эхэлсэн өдрөөс эхлэн календарын 13 хоногт хийж гүйцэтгэнэ.

- 2.10. Энэ гэрээ нь хоёр талын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр болж, талууд харилцан хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр дуусгавар болно.
- 2.11. Гүйцэтгэгч нь инженер геологийн судалгааны дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ.
- **Хээрийн ажил:** 15 метрийн гүнтэй 2 кооног өрөмдөх
 - **Лабораторын ажил:** Физик шинжилгээ хийх
 - **Суурин боловсуулах ажил:**
 - Зураг график боловсруулах, техникийн тайланг нэгтгэн бичих
 - Улсын экспертизээр батлуулах
- Ажлыг MNS стандартын дагуу хөрс судлалын TL-78 стандарт хэмжил зүйн газрын итгэмжлэгдсэн лабораторит итгэмжлэлийн хүрээнд хийж гүйцэтгэнэ.

ГУРАВ. Гэрээт ажлын үнэ, ажлын хөлс төлөх

- 3.1. Гэрээт ажлын нийт хөлс 4 478 718.75 /дөрвөн сая дөрвөн зуун далан найман мянга долоон зуун арван найман төгрөг далан таван / төгрөг байхаар талууд харилцан тохиролцов. Тус үнийн дүнд НӨАТ болон холбогдох татвар, хураамж, бусад зардлууд багтсан багц үнэ бөгөөд цаашид өөрчлөхгүй байхаар талууд тохироцов..
- 3.2. Захиалагч тал хээрийн судалгааны ажил эхлэхээс өмнө гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш гэрээт ажлын нийт хөлсний 50% /тавь/ хувь болох 2 239 359.38 /хоёр сая хоёр зуун гучин есөн мянга гурван зуун тавин есөн төгрөг гучин найман /төгрөгийг гүйцэтгэгчид нэхэмжлэлийн дагуу Голомт банкны 2205021017 тоот дансанд шилжүүлнэ.
- 3.3. Захиалагч талд экспертизээр батлагдсан тайланг хүлээлгэн өгч гэрээт ажлыг бүрэн дууссаны дараа, захиалагч ажлын гүйцэтгэл, тайлан материалыг гэрээнд заасан нөхцөл, чанарын шаардлага хангасан гэж үзэж хүлээн авсан өдрөөр тасалбар болгон гэрээ дүгнэсэн акт баталгаажсанаас хойш нэхэмжлэлийн дагуу 30 хоногт багтаан гүйцэтгэгчийн Голомт банкны 2205021017 тоот дансанд гэрээний үлдэгдэл төлбөр 50% /тавь/ хувь болох 2 239 359.37 /хоёр сая хоёр зуун гучин есөн мянга гурван зуун тавин есөн төгрөг гучин долоон /төгрөгийг шилжүүлнэ.

ДӨРӨВ. Талуудын эрх, үүрэг

Захиалагч тал:

- 4.1. Ажлын гүйцэтгэлийг ажлын даалгаврын дагуу гүйцэтгэн биелүүлээгүй тохиолдолд ажлын хөлс төлөхгүй байх, хүлээн авахаас татгалзах, гэрээг цуцлах эрхтэй.
- 4.2. Бодит зүйлээс шалтгаалан Захиалагч талын хүсэлтээр ажлын хэмжээ болон үнэлгээ нэмэгдэх буюу хасагдах тохиолдолд Гүйцэтгэгч талтай харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан, энэ тохиолдолд ажлын гүйцэтгэлээр санхүүжилтыг тооцно.
- 4.3. Гэрээт ажлын хөлсийг гэрээний үүргийн дагуу хугацаанд нь төлөх үүрэгтэй.
- 4.4. Тухайн объектийн газрын захирамж, байрзүйн зураг болон техникийн даалгаврыг geotechnics@geo-mongol.mn и-мэйл хаяг руу явуулна.
- 4.5. Өрөмдлөгийн талбайд шаардагдах цахилгаанаар хангах буюу талбайг чөлөөлж ажлаа явуулахад саадгүй байхыг захиалагч тал бүрэн хариуцана.
- 4.6. Өрөмдлөг хийх цэгийг захиалагч тал газар дээр тавьж баталгаажуулна. (Газар доогуурх шугам сүлжээ, цахилгааны трасс байгаа эсэх...)
- 4.7. Өрөмдлөг хийх цэгийг захиалагч тал баталгаажуулж, өрөмдлөг хийх боломжоор хангана.

Гүйцэтгэгч тал:

- 4.8. Гэрээнд заасан ажлын хөрсний шинжилгээг MNS стандарт болон холбогдох норм норматив технологийн дагуу чанарын өндөр түвшинд гүйцэтгэнэ.
- 4.9. Гүйцэтгэгч нь инженер-хайгуулын судалгааны ажлыг захиалагчаас өгсөн техникийн даалгаврын хүрээнд орчин үеийн техник технологийн зохих түвшинд хийж, тогтоосон стандартын дагуу техникийн дүгнэлт гаргаж өгнө.
- 4.10. Захиалагчаас өгсөн техникийн даалгавар, ажлын төрөл, хэмжээг тодруулах, тэр хүрээнд нэмэлт мэдээлэл гаргуулж болно.
- 4.11. Захиалагчийн тавьсан шаардлагыг бүрэн биелүүлж ажиллах үүрэгтэй.
- 4.12. Хот дотор өрөмдлөг хийх явцад газар доорхи цахилгаан шугам сүлжээтэй холбоотой асуудал үүсвэл гүйцэтгэгч тал хариуцахгүй болно.
- 4.13. Ажил гүйцэтгэхэд шаардлагатай багаж тоног төхөөрөмжийг станцын хашаанд оруулах үед тоо хэмжээг харуулд бүртгүүлэн эрх бүхий албан тушаалтнуудын зөвшөөрөл, хяналтаар нэвтрүүлнэ.
- 4.14. Ажил гүйцэтгэгч нь станцын хашаанд нэвтрэх үнэмлэх авч, захиалагчийн дотоод дүрэм, журам, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм журамыг мөрдөн ажиллана. Covid-19, Корона вирусын вакцины хоёр, гурав дахь тунг хийлгэсэн байх, эсвэл корона вирусын PCR шинжилгээнд хамрагдсан ажилтнуудыг станц руу тогтоосон хуваарийн дагуу нэвтрүүлнэ. Захиалагч талын зөвшөөрлөөр шаардлагатай үед илүү цагаар ажиллаж болно. B

ТАВ. Давагдашгүй хүчин зүйлс

- 5.1. Холбогдох хууль тогтоомжинд заасан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 5.2. Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

ЗУРГАА. Хариуцлага


- 6.1 Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс нөгөө талд учирсан хохирлыг бүрэн хариуцаж нөхөн төлөх буюу арилгах үүрэгтэй.
- 6.2 Захиалагч тал төлбөрийг хугацаанд нь шилжүүлээгүй тохиолдолд үлдэгдэл үнийн дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд 0,1 хувьтай тэнцэх алданги төлнө.
- 6.3 Гүйцэтгэгч тал нь гэрээт ажлыг гэрээгээр тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэн захиалагчид ажлыг хүлээлгэн өгөөгүй хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх алдангийг төлнө. Алдангийн нийт хэмжээ гэрээний үнийн дүнгийн 10%-иас хэтрэхгүй байна.


ДОЛОО. Бусад зүйл

- 7.1 Ажил гүйцэтгэх явцад гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 7.2 Энэхүү гэрээтэй холбогдон үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргааныг гэрээг байгуулсан эрх бүхий этгээдүүд эвийн журмаар шийдвэрлэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд маргааныг Монгол улсын хуулийн дагуу харьяа шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 7.3 Гэрээт ажлын улсын экспертизийн томилгоо болон батлагдах хугацаа нь гүйцэтгэгч талтай хамааралгүй болно.


- 7.4 Энэхүү гэрээг 4 хувь үйлдсэн бөгөөд захиалагч тал 3 /гурав/-н хувь гүйцэтгэгч тал 1 /нэг/ хувийг авах бөгөөд хувиуд ижил эрхтэй.
- 7.5 Захиалагчийг төлөөлж гэрээний үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн Зуухан цехийн дарга Э.Ариунболд хариуцан ажиллана. Утас-99727172.
- 7.6 Нийлүүлэгчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг “Инженер геодези” ХХК-ийн захирал Ц. Билэг хариуцан ажиллана. Утас- 77278899


ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН
ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД ЕРӨНХИЙ
ИНЖЕНЕР
Ч. ЦОГТСАЙХАН 
Гарын үсэг:

СЭЗХ-Н ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ НЯГТЛАН
БОДОГЧИЙН АЖИЛ ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ
Ө. УДВАЛ 
Гарын үсэг:

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Г.ЭРДЭНЭБИЛЭГ
Гарын үсэг:

ЗУУХАН ЦЕХИЙН ДАРГА
Э. АРИУНБОЛД 
Гарын үсэг:

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН
Г.САРУУЛ 
Гарын үсэг:

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН
Ш. ГАНТУЛГА 
Гарын үсэг:

Хаяг: Монгол улс, Улаанбаатар

хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1

Утасны дугаар: 77111251

РД: 6021646

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ
Ц.БИЛЭГ
Гарын үсэг: 

Хаяг: УБ хот БГД 10-р хороолол, 65-А корпус

Утас: 77278899

РД: 2635003

Баянзүрх дүүргийн Амгалан дулааны станцын өргөтгөлийн барилгын талбайн зинженер геологийн судалгааны үнийн санал

№	Ажлын нэр, төрөл	Үнэлгээ зохиосон үндэслэл	Хэмжих нэгж	Ажлын хэмжээ	Нэгж үнэ /төгрөг/	Нийт үнэ
1. Бэлтгэл ажил						
1.1	Тусгай тоноглолтой өрмийн машин (ирж очих)		км	0	0.00	0.00
Бэлтгэл ажлын дүн						0.00₮
2. Хээрийн ажил						
2.1 Өрөмдлөгийн ажил						
2.1.1	15 метрийн гүнтэй 2 цооног	БНбД 81-117-13	т/м	30	65,000	1,950,000.00₮
Хээрийн ажлын нийт дүн						1,950,000.00₮
3. Лабораторийн ажил						
3.1 Физик шинжилгээ						
3.1.6	Физик шинжилгээ	БНбД 81-117-13	дээж	15	85,000	1,275,000.00₮
Лаборатори ажлын нийт дүн						1,275,000.00₮
Нийт ажлын дүн /2+3/						3,225,000.00₮
4. Суурин боловсруулалтын ажил						
4.1	Зураг график боловсруулах, техникийн тайланг нэгтгэн бичих, олшруулах,	БНбД 81-117-13	%	25		806,250.00₮
4.2	Улсын экспертизээр батлуулах	БНбД 81-117-13	%	5		40,312.50₮
Суурин боловсруулалтын ажлын дүн						846,562.50₮
Судалгааны ажлын нийт дүн /1+2+3+4/						4,071,562.50₮
НӨАТ				%	10	407,156.25₮
Судалгааны ажлын нийт дүн: НӨАТ орсон						4,478,718.75₮

MNS стандартын дагуу хөрө судлалын TL-78 стандарт хэмжилзүйн газрын итгэмжлэгдсэн лабораторит итгэмжлэлийн хүрээнд хийж гүйцэтгэнэ.

Үнэлгээг зохиосон У.Түвшин Инженер-геологи, Геотехник, Гидрогеологи Геофизикийн группийн дарга
Ц. Тэгшбилэг

